

СОЁМБО МЭДЭЭ

ЗАСГИЙН ГАЗРЫН ЭЭЛЖИТ ХУРАЛДААН

СОНСОГЧДЫН БАЙРАНД 200 ОР ДЭЛГЭНЭ

Засгийн газрын ээлжит хуралдаан өчигдөр боллоо. Тус хуралдаанд хэлэлцсэн асуудлыг товчоор хүргэж байна.

- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн тухай болон дээрх хуулиудын төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр болов.

- Улсын хэмжээнд 233 мянга орчим иргэнийг дархлаажуулалтад хамруулаад байна. Зургаан эмнэлгийг 1,440 ороор өргөтгөж, уламжлалт анагаах ухааны зургаан эмнэлгийн 400, есөн тусгаарлах байранд 620 ор, 400, Бөхийн өргөөнд 100 ор дэлгэхээр бэлдэж байна.

- "Эрүүл мэндийн аюулгүй байдлыг бэхжүүлэх хөтөлбөр-Дэд хөтөлбөр-1"-ийн зээлийн хэлэлцээрийн төслийг дэмжив. Азийн хөгжлийн банкнаас 15 жилийн хугацаатай 100 сая ам.долларын зээл авахаар төлөвлөж байна. Үүнийг

цар тахлын эдийн засаг, төсөв, эмзэг бүлэгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд зарцуулах юм.

- "Соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Армени Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн төслийг дэмжив. Хэлэлцээр байгуулснаар оюутан солилцоог баталгаажуулах, ялангуяа анагаах ухааны чиглэлээр монгол оюутнуудыг бусад оронд сургах, соёл, урлагийн салбарын хамтын ажиллагааг сэргээх, шинжлэх ухаан, технологийн хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлэх зэрэг боломж бүрдэнэ. Арменийн анагаах ухааны их сургуулийн диплом нь Европын орнуудад хүлээн зөвшөөрөгддөг байна.

- Орчин цагийн боловсрол, Шинжлэх ухааны салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ой 10 дугаар сард болно. Ойн хүрээнд олон улсын боловсролын сайд нарын чуулга уулзалтыг зохион байгуулахаар болов. Уулзалтаар цахим шилжилт, шинэ зууны иргэн бэлтгэх багш, тэгш хамтран сургалт, насан туршийн боловсрол, боловсрол дахь түншлэл зэрэг асуудлыг хэлэлцэж, гэрээ, хэлэлцээр байгуулах юм. Уулзалтад 30 гаруй орны сайд оролцох төлөвтэй байна.

ҮЙЛ ЯВДАЛ

ЭЛЧИН САЙДЫН ЯАМНЫ ДЭД ТЭРГҮҮНТЭЙ УУЛЗАЛТ ХИЙВ



БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны дэд тэргүүн Жэймс Холдерийг өчигдөр хүлээн авч уулзлаа. ИБУИНХУ-ын Элчин сайдын яам нь Умард Атлантын Гэрээний Байгууллагын элч, төлөөлөгч байгууллага болсонтой холбогдуулж манай улсын Зэвсэгт хүчний "НАТО"-той харилцах харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцов.

Хурандаа Б.Бат-Эрдэнэ энэ үеэр тус Элчин сайдын яам нь "НАТО"-ийн элч байгууллагаар сонгогдсон

явдалд нэн тэргүүнд баяр хүргээд Монгол Улсын Зэвсэгт хүчин, "НАТО"-ийн харилцаа, хамтын ажиллагааны талаар товч танилцуулан цаашид олон чиглэлээр хамтран ажиллах санал санаачлагыг дэвшүүлж, өнөөгийн түвшнийг ахиулах хүсэлтэй байгаагаа онцоллоо.

Харин ноён Жэймс Холдер Батлан хамгаалах яаманд хүлээн авч уулзаж байгаад талархал илэрхийлээд НАТО болон Монгол Улсын харилцаа, хамтын ажиллагааны гүүр болсон энэхүү хариуцлагатай үүргийг гүйцэтгэх болсноо онцолж, манай талаас дэвшүүлсэн санал санаачлагыг түргэн шуурхай уламжилж, дэмжлэг үзүүлж ажиллахаа мэдэгдлээ.

ЦЭРГИЙН ШТАБ 100 ЖИЛД...

ЭХ ОРОН, ЭР ЦЭРГЭЭ СУРТАЛЧЛАВ

Өмнөговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб



Тус Цэргийн штаб түүхт ойн хүрээнд аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтаж аймгийн иргэд олон нийтэд, Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, ахмад дайчдын гавьяат үйлсийг алдаршуулах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, хүүхэд, залуучуудад эх оронч хүмүүжил төлөвшүүлэх, улс орны тусгаар тогтнол, түүхэн уламжлалыг түгээх олон талт ажил, арга хэмжээг зохион байгуулав.

Тодруулбал, Зэвсэгт хүчний 167 дугаар ангид ажиллаж байсан бэлтгэл дэд хурандаа Л.Эрдэнэбилэг, бэлтгэл хошууч И.Баттулга, Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн бэлтгэл ахлагч З.Лхагвасүрэн, гал унтраах 21 дүгээр ангийн гал сөнөөгч бэлтгэл ахлах ахлагч Т.Бүүвэйбаатар нарын "Бидний түүх" сэдэвтэй хөрөг нэвтрүүлгүүдийг бэлтгэн орон нутгийн "Алтанговь", "Говь" зэрэг телевизээр гаргасан ба Өмнөговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын цахим хуудсанд байршуулан

үзэгчдийн хүртээл болгов.

Мөн ахмад, дунд, залуу үеийг хамруулсан "3 үеийн уулзалт", насан туршийн боловсролын төвтэй хамтран "Эх оронч Монгол хүн" телевизийн ярилцлага, "Эрхмийн дээд монгол эр хүн" эсээ бичлэгийн уралдаан зэргийг зохион байгууллаа. Түүнчлэн 2020 оны 1, 2 дугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдсан цэргүүдийн ар гэрт хүндэтгэлийн захидал илгээв.

Тус аймагт үйл ажиллагаагаа явуулж буй төрийн цэргийн байгууллагууд болох Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн ангиудад алба хааж байгаа хугацаат цэргийн алба хаагчдын сургалт бэлтгэл, бэлэн байдал, тэдний цэц мэргэнийг шалгах үүднээс "буудлага", "гар гранат"-ын тэмцээн зохион байгуулан явуулж шилдгүүдийг шалгаруулав.

Халхын голын болон чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин А.Буджав, Г.Сүхбаатар нарт орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойгоор Засаг дарга, Цэргийн штабын дарга нар хүндэтгэл үзүүллээ.

БУЛГАН АЙМАГТ "МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР"-ӨӨР ...

Булган аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын 110, Зэвсэгт хүчний 100 жилийн ойн хүрээнд тус цэргийн штаб цөөнгүй арга хэмжээг амжилттай зохион байгуулав.

Тодруулбал, аймгийн хэмжээнд буюу 16 сум, 1 тосгоны Ерөнхий боловсролын дунд сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сурагчдын дунд "Зэвсэгт хүчин-100" гар зургийн уралдааныг зарлан, дүгнэж шалгарсан бүтээлүүдийг ЗХЖШ-т хүргүүлсэн бөгөөд уралдааны нэгдсэн шалгаруулалтад тус аймгаас оролцогчдын гурван бүтээл шагналт байрт шалгарав.

Мөн 2020 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлагаар Зэвсэгт хүчин болон Хилийн цэрэгт цэргийн алба хааж байгаа дайчдаа эргэх, тэдний ар гэрт Зэвсэгт хүчний 100 жилийн ойн мэндчилгээ бүхий Цэргийн штабын даргын талархлын

захидлыг хүргүүлэх, Батлан хамгаалах туслах нийгэмлэгтэй хамтран Нутгийн удирдлагын ордны ажилчин, алба хаагчдын дунд "Зэвсэгт хүчин 100" хийн буудлагын тэмцээн зэргийг зохион байгуулав.

Түүнчлэн баярын өдрөөр төрийн цэргийн байгууллагуудтай хамтран Булган аймгаас төрөн гарсан баатруудын хөшөөнд цэцэг өргөн хүндэтгэл үзүүлсэн юм. Мөн ойн баярын арга хэмжээний хүрээнд аймгаас төрөн гарсан генералуудын цахим мэндчилгээг иргэдэд хүргэхээс гадна Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын офицер ахлагч, зарим сумдын Тамгын газрын дарга нарыг Батлан хамгаалах болон бусад салбарын шагнал, аймгийн Тэргүүний ажилтан тэмдэг, жуух, баярын бичгээр шагнасны зэрэгцээ 18 нас хүрсэн оюутан, сурагчдын төлөөлөлд цэргийн үүрэгтний үнэмлэхийг гардууллаа.



ЦАГ АГААР	
УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
8°C	-7°C
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
43°C	27°C
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
15°C	4°C

ВАЛЮТЫН ХАНШ		
ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,845.0	2,858.0
EUR	3,363.0	3,428.0
CNY	435.50	439.80
RUB	37.53	39.26
JPY	25.90	26.53
KRW	2.46	2.57

КОВИД-19 МЭДЭЭ	
ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	218
НИЙТ БҮРТГЭГДСЭН	5610
ЭДГЭРСЭН	3947
НАС БАРСАН	9

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ	
ШИНЭЭР НЭМЭГДСЭН	4
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	237
ЭДГЭРСЭН	1046
НИЙТ БАТЛАГДСАН	1283

ӨРНИЙН ЗУРХАЙ

2021.03.25
/ПҮРЭВ ГАРАГ/

ХАВРЫН ДУНД ЦАГААГЧИН ТУУЛАЙ САРЫН ТАВАН ШАР ХАР БИЧ ӨДӨР

Үс засуулвал:
Өвчин эмгэг ирнэ

Наран ургах, шингэх:
06.49-19.11

Барилдлага: Үл зохилдох

Шүтэн барилдлага: Хуран үйлдэхүй

Суудал: Үс

Аргын тооллын 3 сарын 25, Бархасвадь гараг. Билгийн тооллын 12, Үнэг одтой, хар бич өдөр. Өдрийн наран 6 цаг 45 минутад мандан, 19 цаг 11 минутад жаргана. Тухайн өдөр хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба сүм дуганыг сэргээх, бүжиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, хур оруулах, дархны үйлд сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийх, гөлөг тэжээхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

АХЛАГЧ Ю.ЦЭДЭНБАЛД ӨРГӨӨ ЦАГААН ГЭРТЭЙ БОЛЛО

Зэвсэгт хүчний 119 дүгээр анги

"Монгол цэргийн өдөр", орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100



жилийн ойг тохиолдуулан ангийн ахлагчийн зөвлөлөөс сайн үйлсийн аян өрнүүлээ. Тус ангийнхан орон нутгийн ард иргэдэд хандсан бүтээлч ажлууд болон алба хаагчдынхаа нийгмийн хамгааллыг дээшлүүлэх зорилгоор сайн үйлсийн аяныг явуулж хэвшсэн бөгөөд энэ удаад ахлагч Ю.Цэдэнбалын гэр бүлд өргөө цагаан гэр, тавилгын хамт бэлэглэжээ. Тус ангийн захирагч, хурандаа А.Бүрнээбаатар "Түүхт ой гээд бид баярлаад өнгөрөхөөс илүү алба хаагчдынхаа ажиллах орчныг сайжруулж, нэгнийхээ нийгмийн хамгааллыг дээшлүүлэх эрхэм зорилго тавьсан" хэмээн онцолж байсан юм.

ЭСЭЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААН ШИЛДГҮҮД ТОДРОВ

Зэвсэгт хүчний 325 дугаар анги

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб болон Хөвсгөл аймаг дахь Монгол цэргийн нэгдсэн холбооны салбар зөвлөлөөс төрийн байгууллагуудын ажилтан алба хаагчдын дунд зарласан "Эх оронч үзэл бидний оролцоо" сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг амжилттай зохион байгуулж явууллаа.

Төрийн байгууллагуудад ажиллаж буй залуучуудад эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэх, тэдний сэтгэн бодох, найруулан бичих ур чадварыг дээшлүүлэх зорилгоор

зохион байгуулан явуулж буй тус уралдаанд Хилийн цэргийн 0257 дугаар ангийн нягтлан бодогч Я.Эрдэнэтүнгалаг, Зэвсэгт хүчний тусгай салбарын ротын ахлах планшечин, дэд ахлагч Б.Содцэцэг, аймгийн ШШГГ-ын тасгийн дарга, ахмад Г. Номунтуяа нар эхний гурван байрт тус тус шалгарч өргөмжлөл, үнэ бүхий зүйлсээр шагнууллаа.

Уралдаанд амжилттай оролцож хоёрдугаар байрт шалгарсан дэд ахлагч Б.Содцэцэгт Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн удирдлага, хамт олон баяр хүргэж, ажил хөдөлмөрийн өндөр амжилтыг хүслээ.



"ЭХ ОРНЫ ЦЭРЭГ" ЯРУУ НАЙРГИЙН НААДАМ БОЛЛО

Түүхт ойн хүрээнд Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн тусгай салбарын хамт олон Завхан аймгийн Сонгино сумын Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн сурагчдын дунд "Эх орны цэрэг" сэдэвт яруу найргийн наадмыг зохион байгуулав.

Өсвөр үе, хүүхэд залуучуудад эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэх зорилгоор зохион байгуулагдсан тус яруу найргийн наадамд нийт 38 сурагч өөрсдийн бичсэн шүлгээрээ

өрсөлдсөнөөс сурагч П.Анударь, Т.Мөнх-Оргил, М. Долгосүрэн нар эхний гурван байрт тус тус шалгарлаа.

Энэхүү наадамд сурагчид идэвхтэй оролцож байгаад талархаж Сонгино сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Г.Баатарсүрэн, багш А.Золжаргал нар тус салбарын удирдлага, хамт олонд тусгайлан баяр хүргэсэн юм.

Ахмад Н.МӨНХБААТАР

"МИНИЙ ААВ, ЭЭЖ АГААРЫН ЦЭРЭГ"

Зэвсэгт хүчний 337 дугаар анги

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан ангийн офицер, ахлагч, ажилтан алба хаагчдын гэр бүлийн дунд "Миний аав, ээж агаарын цэрэг" гар зургийн уралдааны зохион байгууллаа.

Ковид-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан ангийн алба хаагчийн хүүхэд багачуудын чөлөөт цагийг

зөв боловсон өнгөрүүлэх зорилготой тус тэмцээнийг зохион байгуулснаас дөрвөн бүтээл шилдгээр шалгарсан юм.

Мөн ангийн эмэгтэйчүүдийн зөвлөлөөс "Тиффани мед" олон улсын эмнэлэг болон TV9 телевизийн "Мөрөөдөл биелдэг юм" нэвтрүүлгийн хамт олонтой хамтран ахмад У.Ганбаатар, ахлах ахлагч Л.Булгантуяа нарыг дээрх эмнэлэгт 1.000.000 төгрөгийн эмчилгээ хийлгэх эрхийн бичгээр тус тус урамшууллаа.



ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛБЭ

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, унтраах үйл ажиллагаанд оролцох үеийн аюулгүй байдлын талаар сэрэмжлүүлэг хүргүүлэх тухай зөвлөмжийг Зэвсэгт хүчний Хяналт шинжилгээ үнэлгээний газраас хүргүүлж байна.

Манай улсад жил бүр болзошгүй газар хөдлөлтийн болон бусад төрлийн гамшгийн аюулгүй байдлын эрсдэлт байдлын түвшин байнга өсөн нэмэгдэж байгаагийн зэрэгцээ хүмүүсийн санамсар болгоомжгүй байдал, цахилгаан эрчим хүчний сүлжээний хэвийн бус ашиглалт, дэлхийн дулаарал, хуурайшилтын байдлаас нөлөөлсөн ахуйн ба объектын, ой хээрийн гал түймрийн улмаас 50-60 хүн тогтмол амь насаа алдаж, төр, аж ахуйн нэгж, байгууллага, ард иргэдийн үлэмж хэмжээний өмч хөрөнгө, олон мянган га газар, тариалан, малын бэлчээр, ойн шимт талбай сүйтгэгдэж байна.

Сүүлийн 10 жилийн байдлаар байгалийн болон бусад аюулт үзэгдэл, гамшиг, төрөл бүрийн гал түймрийн улмаас 700 гаруй насанд хүрсэн хүн, бага насны хүүхдийн амь нас үрэгдэж, мөн олон зуун насанд хүрсэн хүн болон бага насны хүүхэд бэртэж, хөгжлийн бэрхшээлтэй болжээ.

Өнгөрсөн оны гуравдугаар улирлын эцсийн байдлаар өвхөн нийслэлийн хэмжээнд 2407 удаа объектын гал түймэр гарч, үүний улмаас 64 хүн амь насаа алдсаны 16 нь бага насны хүүхэд байв. Мөн түлэгдэж гэмтсэн 35 хүний 3 нь бага насны хүүхэд байгаа ба 341 гэр, 141 төрөл бүрийн орон сууц, бусад 144 барилга байгууламж, 240 машин техник шатаж, төр, аж ахуйн нэгж, хувийн өмчид 10 орчим тэрбум төгрөгийн хохирол учруулжээ.

2021 оны 03 дугаар сарын дунд үеийн байдлаар улсын хэмжээнд гарсан нийт гал түймрийн улмаас 25 насанд хүрсэн хүн, бага насны хүүхдийн амь нас үрэгдсэн нь гал түймрийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь онцгой анхаарал хандуулах тулгамдсан асуудал болж буйг харуулж байна.

Түүнчлэн, шалтгаан нь тогтоогдоогүй ба санаатай үйлдлээс үүдсэн төрөл бүрийн гал түймрийн тоо өссөөр байгаад байлдааны зэвсэг, техник, галт хэрэглэл, тэсрэх бодис, шатах, тослох материал зэргийг их хэмжээгээр хадгалж, тэдгээртэй тогтмол харьцаж ажилладаг онцлог бүхий Зэвсэгт хүчний хэмжээнд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, унтраах бэлэн байдлыг хангах асуудалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.

Иймд "Гамшгаас хамгаалах тухай", "Галын аюулгүй байдлын тухай" "Хөдөлмөрийн тухай", "Тамхины хяналтын тухай", "Ойн тухай" хууль, гамшгаас хамгаалах тухай ба гал түймрийн улсын хяналтын дүрэм, Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, стандарт, техникийн нормативын заалтууд, Батлан хамгаалахын сайдын 2007 оны 64, ЗХЖШ-ын даргын 2007 оны 365, 2004 оны 547, 2009 оны 520, 2011 оны А/612 дугаар тушаал, "Цэргийн дотоод албаны дүрэм", "Цэргийн албыг зохион байгуулах заавар"-ыг тус тус үндэслэн, ой, хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар арга зүйн зөвлөмж, сэрэмжлүүлийг хүргэж байна.

ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМЭР

Жил бүр гарч буй ой, хээрийн түймрийн 90 гаруй хувийг ойн түймэр эзэлдэг. Ойн түймэр нь маш аюултай бөгөөд ой мод, амьтан ургамал устаж үгүй болох, түймэрт автагдсан хэсгийн дулааны тэнцвэр алдагдах, агаар мандал бохирдох, хөрсний ургамал устах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлдэг. Энэ түймэр нь аянга цахилгаан цахих, галт уул дэлбэрэх, мод хоорондоо шүргэлцэх, сансар огторгуйн биет газарт унах, хүний санаатай болон санамсаргүй үйлдэл гэх мэт олон зүйлээс шалтгаалан үүсдэг ба ихэнх тохиолдолд хүний буруутай үйл ажиллагаанаас үүсдэг байна. Ойн түймрийн 60-70 хувь нь хүн ам суурьшсан газраас таван км радиуст буюу хүмүүс чөлөөт цагаа цэвэр агаарт өнгөрүүлэх дуртай бүсэд гардаг ба хамрах хүрээгээрээ байгалийн томоохон гамшигт тооцогддог. Ойн түймэр маш хурдан тархаж, богино хугацааны дотор хэдэн мянган га ойг сүйтгэж, гэр орон, үйлдвэр, аж ахуйн барилгуудыг шатааж, цахилгаан дамжуулах утсыг тасалж, эдийн засгийн хувьд асар их хохирол учруулдаг. Жил бүр дэлхийд 200 мянган ойн түймэр бүртгэгддэг ба эдгээрийн улмаас 40 сая га ойн талбай шатаж, хүмүүс олноор үрэгддэг байна. 1985 онд Португалид ойн түймрийн үеэр 300 хүн нэг дор амь үрэгдсэн тохиолдол гарч байжээ. Их хэмжээний ойн болон хүлрийн түймэр нь хэт их халуун, хуурайшилттай үед аянга буух зэргээс болон амралт зугаалгаар яваа хүмүүсийн болгоомжгүй үйл ажиллагаанаас үүддэг. Мөн газрын хөрсөнд хатаж үлдсэн хуурай өвс, модны мөчир, хог хаягдлыг шатааж цэвэрлэх үед үүсдэг байна. Ой модонд ихэвчлэн гадаргуугийн түймэр гардаг. Энэ үед ой сүйрч, ширэнгэ, цэцэг, бургас модны үндэс хүртэл шатна. Хуурайшилт ихтэй улиралд салхины нөлөөгөөр оройн түймэр гардаг. Энэ үед модны, ялангуяа шилмүүст модны дээд хэсэг түймэрт амархан өртөж, унтраах ажиллагаанд хүндрэл учруулдаг. Гадаргуугийн түймрийн тархалт хурд 0.1-3 метр/минут байдаг бол оройн түймрийн хурд ялангуяа салхины чиглэлийн дагуу минутад 100 метр хүрдэг. Хүлэр болон ургамлын үндэс шатах үед газрын хөрсөн доогуур шаталт явагдаж, тал бүртээ тархаж шатдаг. Хүлэр нь өөрөө шатах чадвартай, агааргүй нөхцөлд усан доор ч шатах боломжтой байдаг. Шатаж байгаа хүлэр дээр түүний халуун үнс болон шатаж байгаа хүлрийн халуун нурам нийлж, "багана хэлбэртэй хуй салхи" үүсэж, тэр нь хүчтэй салхины нөлөөгөөр хол газар тархаж, дахин түймэр үүсэж, хүн, мал, амьтан, эргэн тойронд ойр орших хот айл, тосгон сууринг гал түймрийн аюулд өртөх өндөр эрсдэлийг бий болгодог.

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

1. Ангийн үндсэн байрлал, зэвсэг, техник, галт хэрэглэл, тэсрэх дэлбэрэх аюултай бусад зүйлс, эд хэрэгсэл, ШТС, ШТМ хадгалах болон бусад бүх төрлийн агуулах, харьяа хээрийн байгууламжуудын хээрийн түймрээс хамгаалах зурвасыг шинэчлэн татаж, агуулах нэг бүрийн ойр орчмын хуурай өвсийг журам, зааврын дагуу цэвэрлэж, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх.

2. Байгууламжийн түймрээс урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг боловсруулан мөрдөж, байгууламжийн гал, ой, хээрийн түймэр унтраах анхан шатны багаж хэрэгсэлийн иж бүрдлийг хангах.

3. Ангийн байрлал, хээрийн байгууламжуудын аянга зайлуулагч төхөөрөмжүүдийн ажиллагааг мэргэжлийн байгууллагаар шалгуулж, баталгаа гаргуулж ашиглах.

4. Ангийн мэдлийн бүх барилга байгууламж, хээрийн байгууламж, албан тушаалын орон сууцуудын цахилгааны магистрал шугамд үзлэг хийж, галын аюулгүй байдлыг хангах.

5. Ангийн байрлалаас гадна үүрэг гүйцэтгэхээр томилгосон бүрэлдэхүүнд ахуйн ба ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх аюулгүй ажиллагааны зааварчилгаа боловсруулан, судлуулж танилцуулан, гарын үсгээр баталгаажуулах.

6. Хээрийн галлагааны зориулалттай бүх төрлийн зуух, яндан, хатуу, шингэн, хийн түлшээр ажилладаг хээрийн халуун тогоо, бүх төрлийн гэрэлтүүлэг, цахилгааны сүлжээ, тоног төхөөрөмж, хэрэгсэлүүдийн галын аюулгүй байдлыг бүрэн хангах.

7. "Тамхины хяналтын тухай" хуулийн дагуу хяналт тавьж, санамсаргүй, болгоомжгүй байдлаас ба санаатайгаар гал түймэр гаргаж болзошгүй байдлаас байнга урьдчилан сэргийлэх.

8. ШТМ тээвэрлэх, хадгалах, түгээх, ашиглах үеийн галын аюулгүй байдлын шаардлагыг хангаж, ил задгай саванд юүлэх, зориулалтын бусаар ашиглах явдалд хяналт тавьж, бие бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ зохион байгуулах.

9. Ялангуяа зэвсэг, техник, галт хэрэглэл, тэсрэх ба химийн бодис хадгалах агуулах, байгууламжуудын байгууламжийн болон ой, хээрийн түймрийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээнд онцгой анхаарал хандуулж, хариуцах бүрэлдэхүүн, харуул хамгаалалтын сонор сэрэмжийг дээшлүүлэн, холбогдох бүх талын арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах.

10. Болзошгүй гал, ой, хээрийн түймрийн улмаас түлэгдэж гэмтсэн, утаанд хордсон үед хүн эмнэлгийн нэн яаралтай анхан шатны тусламжийг хүн нэг бүр өөртөө болоод бусдад үзүүлэх, гал түймэр унтраах, аврах үйл ажиллагаа явуулах талаар бие бүрэлдэхүүнийг заавал сургаж дадлагажуулах, гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмж, хүн эмнэлгийн иж бүрэн хэрэгсэлээр хангах.

11. Батлан хамгаалахын сайдын 2007 оны 64 дүгээр тушаалын дагуу ой, хээрийн түймэр унтраах 10 хүний бүрэлдэхүүнтэй бүлэг томилж, /хэдэн ч бүлэг байж болно/ сургалт дадлага зохион байгуулан, тус тушаалд нарийвчлан заасан тоо ширхгээр ой, хээрийн түймэр унтраах анхан шатны багаж хэрэгсэлээр хангах.

12. ЗХЖШ-ын даргын 2011 оны А/612 дугаар тушаалаар батлагдсан "Зэвсэгт хүчний анги, салбаруудын ой, хээрийн түймрийн үед ажиллах журам", "Цэргийн хүрээний ба харуулын албаны дүрэм"-ийн "Байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, ослын хөнөөлийг арилгахад цэргийн анги, салбаруудыг оролцуулах тухай" заалтыг судалж, судлуулан, түүний дагуу үйл ажиллагаа явуулах бүх талын бэлэн байдлыг хангаж ажиллахын зэрэгцээ дээр дурдсан хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг судалж, судлуулан, сурталчилж, хэрэгжүүлж ажиллах шаардлагатай.



СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАЛДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор
Хурандаа
САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ

Эхийг "Соёмбо" сонин редакцал бэлтгэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сонин нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029